

Амьс дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,
АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ СӨНИЙ.

14 дөх жилдээ 1962 оны
№ 13 (1157) 2 дугаар сарын 28 ЛХАГВА

Ажил бүхэндээ тэргүүн туршлага, шинэ санаачлагыг нэвтрүүлэе

Манай урагшлах хөгжлийг улам хүргэгдэх хүчин зүйлийн онгоц чухал хэсэг бол шинэ санаачлага, тэргүүн туршлагыг соргогсор хүлээн авч, судлан, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бүх салбарт нэвтрүүлэх явдал мөн.

Энэ бол МАХН-ын 14 дүгээр их хурлын түүхэн шийдвэр, 3 дугаар таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө тоо чанарын бүх үзүүлэлтээр давуулан биелүүлэхийн үндсэн хүч байх ёстой.

Намын Төв Хорооны 6 дугаар бүгд хурал, шинэ санаачлага, «нээлт, шинэ бүтээл, оновчтой самал», тэргүүн туршлагыг өрнүүлж, манай ажилчид, инженер, техникчид, сэхээтэн, эрдэмтдийг татаж оролдуулан, олон нийтийн хөдөлгөөн болгох нь нам, үйлдвэрчний эвлэл, үйлдвэр, аж ахуйн бүх байгууллагын нэн чухал зорилт мөнхийг онцлон заасан билээ.

1961 онд тус аймагт 135 шинэ санаачлага гарсны 110-ыг үйлдвэрлэл, хөдөө аж ахуйд нэвтрүүлэн, тэргүүн туршлага 88-ыг авч хэрэглэсэн байна.

Мал маллагаанд Булган аймгийн Хишиг-өндөр сумын Лениний зам нэгдлийн алдарт хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Очир гуайн туршлагыг нилээд сумын олон арван хоньчин эзэмших болжээ.

Баянзүрх сумын Сүхбаатарын зам нэгдлийн хоньчин эмэгтэй Цэнд, хсн, ямаа нийлсэн 142 хээлтэгч малжиг жилд 2 төлдүүлэх сайхан туршлагатай болсон байна.

Хаврын тариалан, намрын тариа хураалтын ажилд өндөр амжилт гарган, шатхууныг үлэмж хэмжээгээр хэвнэг, техникийн хүч чадлыг дүүрэн ашигладаг тракторчид, комбайнчид, жил бүр хариулсан мал бүрийнхэнд тэлийг өөрсдийн шилдэг алаар бүрэн бойжуулагч малчдын зэрэг нийтийн ажла амьдрал болговол зохих тоо томшгүй тэргүүн туршлага газар бүр гарсаар байна.

Гэтэл энэ дэвшилт аргыг нийтийн болгохоор зохион байгуулалтын тодорхой ажил зохиогдохгүй, «тэргүүн туршлага нэвтрүүлэе» гэдэг хийл шуугиан дэгдсэнээс хэтрээгүй, тэсвэрлэж болшгүй дутагдал нөмөрсөн хэвээр байна.

Авто тээврийн 13 дугаар баазын тэргүүний жолооч, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат нөхөр Хишигтогтох, 1961 оны эхээр машинуудад ээлжийн зэвсэр, үзэлийг жолооч бүр өөрсдөө хийж, ажлын хүч сөлдөг хэргэзлийг хөмнөх, 100 км дутамд орох бөвшинээс 2 литр бензин хэмнэх, машин бүрийн хоногт гүйцэх коэффициентийг 0,64-д хүргэх санаачлага гарган ажилд шинэ баазын захиргаа, тэндэх нам олон нийтийн байгууллага ажил хэрэгчээр дэмжин туслаагүйгээс тэр нь

ажил болсонгүй, түүгээр ч барахгүй жолооч Хишигтогтохын олон зууны явсан туршлага, тэр баазын жолооч бүрийн хурт бөлөөгүй байна. Эрдэнэсант сумын Саруул-амьдрал нэгдлийн 2 дугаар бригадын хоньчин өгөгч Гомбожав, сүүлийн 5 жилийн турш төлөө 500 хонийг билчээрээр дуудаас дээн тарга авхуулан хургы нь хоргодоггүй бойжуулж, хонь бүрээс 1400 грамм ноос ашигладаг туршлагыг тус сумын намын үүр, нэгдлийн ерөнхий хорооны нийтийн хуртээл болгоогүйгээс адил нөхцөлд байгаа III бригадын нийт хоньны тарга хүч муу авагдаж гарз хохирол байнга үзэж байдаг ажээ.

Энэ суурийн зөвхөн хоньчин Сампилын суурт хэвтэр бууцны муугаас болж, одоо 50 гаруй хонь хээл хаяж, нийт хонь нь тарга хүчээ гээж байна. Тэргүүний туршлагын хэмжээлгүйг их ач холбогдол бол хөрсдийг тэргүүнийхээ зэрэгт хүргэж, аль дэвшилтэй сайн бүхэнд хөдөлмөрдлийг сурган далаагажуулах явдал мөн.

Энэ ажлыг байнгын болгох үндсэн хөшүүрэг нь социалист урлалын бүх салбарт жинхэнэ ёсоор өрнүүлэх хэрэгтэй юм.

Ажилчин, малчдын хооронд, хөёр байгууллагын хооронд авсан уралдаант үүргийн гол хэсгийг тэргүүн туршлага, шинэ санаачлагын гухай асуудал эзлэх ёстой.

Энэ үүргээ тойруулан ухуулан тайлбарлах, сэдэвлэгдсэн зүйлүүдийг тэр дор нь үр аргийн тооцоолоон ажил болгоход бүх талаар нь дэмжин туслах ажлыг шуурхай хийх хэрэгтэй.

МАХН-ын Төв Хорооны 2 дугаар бүгд хурлаас тэргүүний туршлагыг олж илрүүлэх, түүнийг судлах, үйлдвэрлэл, ХАА-д нэвтрүүлэх ажил нам, улс, олон нийтийн бүх байгууллага, манай удирдах амилтан бүрийн өдөр дутман ажлын салшгүй хэсэг нь байх ёстой гэж заасан заалтыг манай бүх хариуцлагатан, ухуулагч бүр өөрсдийн цөхрөлтгүй ажлаар биелүүлэх ёстой. Тэргүүн туршлагыг олж илрүүлэх нь хүнтэй хир зэрэг дотно ажиллаж, аль хир ажлыг авхаалжтай хандсаар шийдвэрлэгдэнэ.

Баянзүрх сумын Сүхбаатарын зам нэгдлийн ерөнхий хороо, намын үүр, ажлаараа шалгарсан 100 гаруй хүнд 2-3 хүнийг сургах үүрэг өгч, түүнийг биелүүлэхэд нь туслаж байна. Энэ бол тэргүүний туршлагыг нийтийн хүргээд болгох нэг чухал хэлбэр юм.

Тэргүүний туршлага, шинэ санаачлагыг нэвтрүүлэх ажлыг сум нэгдэл, сангийн аж ахуй, үйлдвэр, худалдааны байгууллагын ШБӨС, комиссууд шууд хариуцан, тодорхой удирдах ёстой.

Аймгийн намын хороонд

Аймгийн намын хорооны товчоо, аймгийн намын 4 дүгээр бүгд хурлыг 1962 оны 3 дугаар сарын 21-нд хуралдуулж, МАХН-ын Төв Хорооны 2 дугаар бүгд хурлын дүн ба аймгийн намын байгууллагуулын зорилтын тухай асуудал хэлэлцүүлэхээр тогтоол гаргав.

Аймгийн намын бүгд хурлыг угтаж, Намын Төв Хорооны 2 дугаар бүгд хурлын шийдвэрийг сурталчлах, биелүүлэх, мал төлөлтийн бэлтгэлийг шуурхай хангаж, төл бүрийг мал болгох, хаврын тариалангийн бэлтгэл ажлыг дуусгах I сарын цохицтой ажил зохиож ажиллахыг сум-нэгдэл, САА-н намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нарт даалгасан байна.

Манай нэгдэлд, мэнд сүрэгтэн олон

Лүн сумын Энх туул нэгдлийн малчид, бог малын төл бүрийг хөрвийн үе шатаар бойжуулж, «төл нэг бүрийг мал болгохын төлөө» чармайн ажлаах байна.

Малчдын дунд хээлтэгч малын хээлийг хануулахгүй байх, гарсан төлөө мэнд байлгах, мал бүрийг онд тарган тавтай оруулах, малаа тоо тосгойгоор нь бүрэн байлгахын төлөө гэсэн урлалын болзлыг биелүүлж, мэнд сүрэгтэн болох хөдөлгөөн өрнөсөөр байна.

Одоогийн байдлаар 2 дугаар бригадын хоньчин Рэнцэндорж 245 хонноос 245 хурга, 78 ямаанаас 78 шиг

Аюур 160 хонноос 160 хурга, 53 ямаанаас 53 шиг, 3 дугаар бригадын Солонмөрөн 175 хонноос 179 хурга, Дамбий 220 хонноос 220 хурга, 5 дугаар бригадын Гомбо 265 хонноос 265 хурга, Жанчив 255 хонноос 255 хурга, 1 дүгээр бригадын Сосорбарам 70 хонноос 70 хурга, Лхамсүрэн 93 хонноос 93 хурга, 37 ямаанаас 37 шигийг хүлээн авч, бүрэн бойжуулж, ямаагаас гадна Сэр Ол, Гельгравжаа, Дамдинсүрэн, Чойжил, Равдаа, Дорж, Лхагва нарын олон малчид гарсан төлөө 100 хувь бойжуулж байна.

Г. Жанчив

Бэлтгэл нь сайн, төл нь бүрэн

1962 онд Баянцогт сумынхан 21649 төл хүлээн авч бойжуулах юм.

Тэд төлийн бэлтгэл хангах 20 хоногийн ажил зохиожээ.

Энэ хугацаанд залуучууд, сумын төвийн ажилчин, албан хаагчид, намын гишүүд, нэгдлийн модны тасгийг хүчээр саравчтай хашаа

14-ийг шинээр барьж, хуучин 11-ийг завссан байна.

Эдгээр хашааны ханыг бүдүүн шургааг зүсэж хийсэн нь хажуугаараа салхи орохгүй, төлийг хөрвийн аргаар бойжуулахад бүрэн тохиромжтой болжээ.

Одоогийн байдлаар хужир, шүү 60 тонн, өмс 100 тонн, хүчит тэжээл 40 тонныг тус тус бэлтгээд байна.

Бог малын төл хүлээн авах 27 суурь саравчтай хашаагаар хангагдаж, 1 суурь нь 500-600 мянган төл, 2-3 өрх, нэг төлийн 110-120 төл хүлээн авах юм.

Төлийн бэлтгэл ажлыг хангахад тус сумын Монгол-Хятадын найрамдал нэгдлийн Бэлчигням даргатай мод бэлтгэх тасгийнхан илүү хүч гарган, саравчтай хашаа 2-ыг барьж, төлийн хайс 819, онгоц 108-ыг хийж, төлийн жижүүрт зориулан агаар гэрлэтэх шилэн дэнлүү, төлд долоолгох хужир шашааж, бэлтгээд төлдөлд шилжүүлжээ.

Одоо сумын хэмжээгээр 3000 шахам бог мал төлөгж, гарсан төл нь бүрэн бойжиж байна.


Сумын төвийн 14 ажилтан төл хүлээн авч бойжуулах ажилд 45 хоногийн хугацаатай ажиллахаар 2 дугаар сарын 14-нд сумын төвөөс суурь, бригадуудад гарлаа.

Бог мал төлөх 2 бригадад газ 51 машин тус бүр нөгийг төлийн тэжээл бэлтгэхэд зориулан 15 хоногийн хугацаатай ажиллаж байна.

Малын эмч, зоотехникч нар мал төлөх айл өрхүүдийг хуваарлан авч, байнга ажиллаж байна.

Баянцогт сумын нам улсын байгууллагууд, нэгдлийн гишүүд «1962 оныг мал өсгөх өргэлтийн он болгох», «төл нэг бүрийг мал болгохын төлөө» нигэж ажиллаж байна.

Б. Хунгуу



Эрдэнэ сумын Монгол-Унгарын найрамдал нэгдлийн ангийн ХЗЭ-ийн гишүүн Мэртинор, 1961 онд 475 тарвага, 1962 оны 1 дүгээр улиралд 120 шувуу, 10 туулай, 8 нохой, 5 үрс агнаж аймгийн тэргүүний бичгийн нэг болжээ.

зургийг Д. Довлогдож

Тэргүүн туршлагыг үйлдвэрлэлд нэвт

Хонио хоёр толгуулсан туршилага

Баянзүрх сумын Сүхбаатарын зам нэгдлийн 5 дугаар бригадын малчин эмэгтэй Цэнд, 1961 оноос нийгмийнхээ 115 хонь, 27 ам ямааг 3 жил дараалан 2 удаа төлүүлж, цаашдаа 1963 онд хонинхоо төлөгт 690, ямаанахаа төлөгт 162, бүгд 852 төлөөр малаа өсгөж, бүх малаа 994 толгойд хүргэх зорилт тавьж ажиллаж байна.

Малчин Цэнд, 1961 онд 1 дүгээр төлөлтөөр 115 хониоос 116 хурга; 27 ямаанаас 27 нинг бойжуулан авсан бөгөөд 2 дугаар төлөлт нь 11 дүгээр сараас эхлэн төлөж 115 хониоос 115 хурга, 27 ямаанаас 27 нинг хуваан авч эрүүл эх бүрэн бойжуулав.

1961 онд бүх малдаа ногоон өвс 12400 кг, сүрөл 1500 кг, хушир 800 кг-ыг бэлтгэж, одоо бүх хээлтэгч, төл малаа нэмэгдэл тэмдэглээр тэмдэж байна.

Цэнд гуай төлийг эхний 14 хоногт эхий нь хамт байлгаж, 14 хоногны дараа төлийг өдөрт ойр газар, цөөн цагаар эхтэй нь хамт билчээрүүддэг байна.

Ингэж ажилдаснаараа төлийн амьдын жин нь хурдан өсч, 5 дугаар сард гарсан төл 10 дугаар сард амьдын жин нь 20-35 кг болдог байна.

Энэ нь хоногт 200-210 граммээр нэмэгддэг.

Ус ноосны урт нь 5-7 см болжээ. Одоо гарч байгаа төл нь бие бялдар сайтай 5,5-6 кг-ын амьдын жинтэй, эх нь тарга хүчээр намраараа байна.

Цэнд гуай ярихдаа: Ер нь малыг жилдээ 2 удаа төлүүлнэгэдэг тиймч хялбар ажил бишээ.

Энэ бол хүний нягт намбай ажиллагаа, урьдаа тавьсан тодорхой зорилт, мал төлөхөд хэрэглэгдэх бүх бэлтгэлийг хир зэрэг хангаснаар л уг ажил шийдвэрлэгдэх юм.

Ялангуяа хээлтэгч, хээлтүүлэгч малчин тарга хүчийг сайн авахуулах явдал хамгийн чухал байдаг.

Иймд би хээлтүүлэгчийг хээлтүүлэгчд орохоос өмнө нэмэгдэл тэмдэглээр байнга тэмдэдэг.

Хээлтэгч мал хавар, зун сайн тарга хүч авч чаднал өвөл төлөхөд тарга хүч нь амархан мууддаггүй юм.

Төлөсний дараа сар хагас болоод хээлтүүлэгчд сруулахад хээлтэгчийн тарга хүч хэвээрээ байдаг юм гэж ярилаа.

Цааш нь: Малаг 2 удаа төлүүлэхэд ашиг шин, үүдлэр угсан муудна гэж байхгүй, харин арчилгаа, маллагаа муу бол энэ зорилт биелэхгүй юм.

Малаг 2 удаа төлүүлэхэд төлөх хугацааг сонгож авах нь хамгийн чухал.

Би өөрөө, 1 дүгээр ээлжийн төлөлтийг 5 дугаар сарын сүүл, 6 дугаар сарын эхээр, 2 дугаар төлөлтийг 11 дүгээр сарын сүүл, 12 дугаар сарын эхээр төлөж гүйцсэн байх нь төл ба эхдээ зүгээр юм уу? гэж болдог.

Энэ үеэр төлүүлэхэд, өвчин өмгөг бага тохиолдох шиг санагдадаг.

Би, малын эмч, зоо техникч нараас өгсөн зөвлөгөөнийг анхараалтай сонсч, тэднийхээ заавраар ажилладаг. Нигэснээр манай малд ямар нэг өвчин, эмгэг гарах нь ховор, үүх явдал байдаггүй юм.

Би, 1962 онд малдаа тохилог ханша саравч барьж, өвөлжөө, хавар жааныхаа бууцгыг нуруулааж, бууцны байнгын өвчтэй болохын дээр бие засах газар, муу уснд нүх, малын хаг хийх нүх зэргийг бэлтгэж ажиллана гэв.

Цэнд гуай өнгөрсөн жил малынаа ноос, нооцуур, хялгас, сүүг, давуулан биелүүлсэн манай тэргүүний малчны нэг юм.

Малч бага эмч Бамбасүрэн

Хот айлын хүмүүжил

Баянзүрх сумын Сүхбаатарын зам нэгдлийн үхрийн үржил сайжруулах бригадын Доржгодов ахлагчий суурь, суурийнхаа хүмүүжлийн ажлыг 7 хоногт 2 удаа, нам засгийн тогтоол шийдвэр, аймаг сумынхаа төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхтэй нягт холбоон явуулдаг байна.

Доржгодов, МАХН-ын 14 дүгээр их хурлын шийдвэр, III таван жилийн төлөвлөгөөний зорилт, мал өвөлжилт, төлийн бэлтгэлийг хангах, «төл болгоныг мал болгохын төлөө» гэсэн Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоол, улс, аймаг, сумын болзлыг дэс дараалалтай судлах ажлыг суурийнхаа хөдөлмөрдчийн дунд олон хэлбэрээр зохиож байна.

Ухуулагч Доржгодов, суурийнхаа саалчин Батсүх, малчин Жадамба нарыг өөрийн жишээгээр сургаж, хэвлэл уншлаа, хот айлын хүмүүжлийг зохиоход идэвхтэй ажиллуулдаг байна.

Эд нар хэвлэл уншлагыг явуулахдаа унших зүйлийг 7 хоногийн өмнөөс сонгон авч, өөрдөө уншиж, тэмдэглэл хийж, биеэ бэлтгээд хүмүүст ойлгомжтой унших, энгийн яриагаар үзгэрчлэн ярьж тайлбарлах, дараа нь асуулт хариулт явуулдагас хүмүүсийн ойлгоц сайн болдог байна.

Үүний дунд тэр суурийн бүх хүмүүсийн ухамсар дээшилж, нийгмийн хөдөлмөрт жигд оролцох болж, хотын ба хувийн ариун цэвэр нь эрс сайжирч тус суурийн төлөвлөгөөт зорилт нь ч амжилттай биелж байна.

1962 онд хүлээн авах төлийн бэлтгэлийг хангаж, 50 тугалын багтаамжтай уртаараа 5 метр 60 см, өргөнөөрөө 2 метр 70 см,

урд талын дээсэрт 3 шилэн цонхтой, тохилог сайхан пунз нэгийг өвөлжөөндөө барьж дуусгаад, түүнийхээ адил нэг пунзийг хаваржаандаа барихаар мод, материалыг бэлтгэж татаад, барих ажилдаа орсон байна.

Малын тэмдэгийн уртаараа 3 метр модон онгоц 6, суурийнхаа малын тэмдэгийг татах, сургааг, мод зөөх том чарга 2-ыг ашиглаж байна.

Суурийнхаа фондолсон бууцыг хайгуулах сав 1-ийг сургаагаар барьж, билчээрт төлөсөн үнээний тугалыг авчрах 2 тугалын багтаамжтай тусгай хайрцаг бүхий чарга нэгийг хийжээ.

Энэ суурийн хамт олон, 1962 онд саалчид, малчдаас өөрсдийн хариуцаж буйгаа малаа онд тарган оруулж, харьцсан 15 үнээ бүрээсээ 15 тугал бойжуулан, үхэр бүрээсээ 550 грамм хөөвөр, 15 грамм хялгас, үнээ бүрээсээ 550 литр сүү саах, төл дутамо амтлаг цагаан өвс 6 кг, хөх бууц 16 кг бэлтгэсэн байна.

Энэ бол хот айлын хүмүүжлийн ажлыг тогтмол зохиосны үр дүн мөн.

Энэ суурийн хамт олон одоо социалист хөдөлмөрийн төлөө бригад бөлохоор үүрэг яваад ажиллаж байна.

Доржгодовын удирдсан суурийн жишээгээр суурь, хот айл бүхэн хот айлын хэвлэл уншлагыг тогтмол болгон, бригадынхаа өмнө зогсож байгаа ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд бүх нийтийн хүчээр дайчлан зохион байгуулах одоогийн дайчин зорилтын нэг мөн.

Д. Мэнджаргал

Манай аймагт нэвтрүүлсэн шинэ санаачлага, тэргүүн туршлагын үр дүн

Аймгийн АДХГ Захиргаа, намын хороо, МАХН-ын XIV их хурал, Намын Төв Хорооны VI бүгд хурлын түүхт шийдвэрийг биелүүлэхийн тулд аймгийн хэмжээгээр 1961 онд шинэ бүтээл, оновчтой санаа, тэргүүний туршлагыг дэмжин дэлгэрүүлэх нилээд ажил зохиов.

Үүнд: Зэргээд аймаг, сум болон ардын ардынхсан орнууд, өөрийн аймагт гарч байгаа тэргүүний туршлагыг судлаж, тусгай төлөвлөгөөг боловсруулан, аймгийн намын бүгд хурлаар батлуулаж, биелэлтийг нь шалгаж, туршлагыг ажилд яаж нэвтрүүлж байгаа тухай сумын захиргаа, намын үүрийн илтгэл сонсголуудыг хурлаар тогтмол хэлэлцэж, гарсан ба дэлгэрүүлсэн туршлагауудаа эхлэгтэн нэгтгэж хэд хэдэн товхимол хэвлэж, аймгийн сонинд тусгай будин байгуулсан зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав.

Үүний дунд аймгийн улс ардын аж ахуй, соёлын салбарт 1961 онд 145 шинэ санаачлага гарсны 110-ыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, тэргүүн туршлага 88-ыг аяч хэрэгсэлээр аймгийн хэмжээгээр 523 мянган төгрөгийг хуримтлаж гаргажээ.

Аймгийн АДХГ Захиргааны нэгдүгээр орлогч ЦЭРЭН

Үүний дотроос 1961 онд аймгийн хөдөө аж ахуйд 34 шинэ санаачлагыг нэвтрүүлж, 25 тэргүүн туршлагыг нийтийн хүртээл болгосон нь 393 мянган төгрөгийн хэмжээт гаргаж, хөдөө аж ахуйн ажилд мэдэгдэхүйц амжилт олов.

Ялангуяа малаг билчээрийн аргаар таргалуулах, Лениний зам нэгдлийн хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Онцрын туршлагыг тус аймгийн нийт сум, нэгдэл, сангийн аж ахуйд нэвтрүүлсэн нь ихээхэн үр дүн өглөө.

Малаг билчээрээр таргалуулах ажлын байдалд 10 дугаар сард бүх малд тарга хүчний үзлэг, шалгалт явуулахад аймгийн бүх адууны 98,9 хувь, үхрийн 96,1 хувь, хонь, ямааны 94,6 хувь нь дунд ба түүнээс дээш тарга хүч авсан байна.

Нөхөр Онцрын туршлагыг аймгийн хэмжээгээр 300 гаруй малчин эзэмшсэний дотроос Бүрэн сумын Бүрндэлгэрэх нэгдлийн хоньчин Ширин, 1960 онд 500 эр төлөг, 300 эр нүдлэн ямааг билчээрийн аргаар таргалуулаж, 1961 онд дунджаар

хонь бүрийг 51,9 кг, ямаа бүрийг 37,8 кг-ын амьдын жинтэй улсын бэлтгэлд тушаасан байна.

1961 онд малын төлийг хөрвийн аргаар бойжуулах аргыг нийт хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн малчдад эзэмшүүлж ажил зохиосноос тус аймгийн бүх сангийн аж ахуй, тугалыг заядуулах, бог малын төлийг хөрвийн үе шагаар эхлээр бойжуулсан бөгөөд хөдөө аж ахуйн нэгдлүүдийн 38,9 хувь нь бог малын төлийг хөрвийн аргаар бойжуулсан нь аймгийн хэмжээгээр төлийн хорогдлыг 1961 онд урьд онохоос 29,2 хувиар багасгасан байна.

1961 онд нэгдлүүдээр гахай, шувуу үржүүлэх ажлыг албадан хийлгэсний дунд манай аймгийн 12 нэгдэл гахайтай, 10 нэгдэл шувуутай болж, одоо 594 гахай, 1260 гахнаатай болж энэ салбараасаа нэгдлүүд 1961 онд 31 мянган төгрөгийн цэвэр ашиг олсон юм.

Тус аймагт нэгдлийн дундын үйлдвэрлэлийг 1961 оноос эхлэн ажиллуулах туршлагыг хоёр чиглэлээр явуулав.

Үүний нэг нь нэгдэл дундын газар тариалан, үүнд: 12 нэгдлийг хамруулан 9541 га тариа ногооны талбай эзэмшүүлжээ.

Нөгөө нь: 12 нэгдлийг хамарсан модны үйлдвэр байгуулж, жилдээ 1,5 сая төгрөгийн мод, материал боловсруулан гаргаж, барилга, хашаа саравчны хэрэгцээг хангах болжээ.

Тус үйлдвэрлэлд аймгийн бүх нэгдлийн 57 хувь хамрагдах болоод.

Хөдөө аж ахуйн нэгдлүүдийг суурьшуулан бэхжүүлэх талаар аймгийн гүйцэтгэх захиргаа, намын хороо, хурлаараа хэлэлцэж тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монгол-Унгарын найрамдал нэгдэл, суурьшуулах суурьшуулах талаар аймгийн заалтыг үндэслэн бүх үхэр, хонийг 100 хувь хашаажуулж, нэгдлийн бригад нь бэхжиж, бригадын доторхи сууриуд нь хэсэг хэсгээрээ улаанбулан, халуун ус, орон сууц, хүүхэд саатуулах газартай болж, гишүүдийн хүмүүжил, амьдралд соёлжилтын байдал нэвтэрч, нэгдлийн гишүүд бүхэн нийгмийн хөдөлмөрт бүрэн оролцох боломжтой болоод.

Энэ нэгдлийн туршлагыг аймгийн нийт нэгдлүүдэд эзэмшүүлэхийн тулд нэгдлийн дарга, бригадын дарга нарыг биечлэн үзүүлж та-

РҮҮЛЭХ НЬ АЖЛЫН ОДООГИЙН ГОЛАРГА МӨН

Шинэ бригадын шингэр бүтээл

Эрдэнэсант сумын Саруул-амьдрал нэгдлийн адуучин Дагва ахлагчтай СХТ бригад байгуулаад 2 сар гаруйхан болж байна.

Энэ бригадынхан 2400 адуу хариулаж байна.

Эд нар авсан үүргээ биелүүлэх талаар зэгсэн ажил хийж амжжээ.

90 гаруй өмнөг морь унасанд, 2 морь үргэнд сургаад, ойрын үед 20 хүргэх гэж байна.

Адуу хөөвөрлөхөд зориулан 1000 адууны багтаамжтай 1,5 метр өндөр чулуун хашаа барьжээ.

«Хөтөл нуурын шанд»-ыг засч адуугаа дулаан цагт задгай урлах болжтой болгосон байна.

Газрын хөдсөн хөрсийг нөвт улаж үе элбэгтэй худаг нөгийг гаргаад байна.

Өвөлжөөнд адуу төжөөх саравчтай хашаа барьжээ.

Одоо нүүдлийн ухуулах байр байгуулан, 200 гаруй номтой, номын сантай болж, энэ байрандаа хэвлэлийн уншлага 40 удаа, үдэлжээ 7 удаа зохиожээ.

Гэр бүлийнхээ хамт 2 жилийн хугацаатай оройн сургууль байгуулан хичээллэж байна.

Гишүүн бүр 300- мал эмнэл-

гийн анхны мэдэгдүүл эзэмших мөн 1 гишүүн нь хүн эмнэлгийн анхны мэдэгдэхүүнтэй болохоор үүрэг авч аяад хүн, малын эмч нараас даалгавар авч, үе үе шалгуулах замаар судалж байна.

Гишүүн Дашзэвэг, Сампил хоёрын гэрэйг сайхан тохижуулсан байна.

Гэрийн цэцэрлэг байгуулан хүүхдээ хүмүүжүүлж, гэр бүлийнхнээ ажилд оруулжээ.

Энэ бригадынхан хялгас, хөөвөр авч, унага бойжуулах бэлтгэлээ хийж дуусаад байна.

Үүнд хайчаа хурцлах, сам, сойзoo бэлтгэх, уурга, уурганы үзүүрээ хүртэл засч авчээ.

Эдний ажлын бэлтгэл ёстой л бүтөрөл дээрээ жин тав болсон байна.

Одоо адуугаа ээлжээр манай байна.

Энэ бригадын хамт олон МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын шийдвэрийг биелүүлэн, хялгас хөөврийн төлөвлөгөөг цаг нь дануулан биелүүлж, унагаагч хоргодоггүй бойжуулахаар зориг бадраггүй ажиллаж байна.

Ө. Чойин

ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙГ УДИРДАХ ГАЗРЫН БОЛЗОЛ

Худалдаа бэлтгэлийн байгууллагууд худалдаа, нийтийн хоол, талхны газар, бэлтгэлийн хүнд хүчир ажлыг механикжуулж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, нэгж үйлдэхүүнд зарцуулах цаг, хөдөлмөр, хөрөнгө, хэмнэх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах, эдийн яс чанарыг сайжруулж, нэр төрөд, тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар дэвшилттэй арга санаачлагдчид, чадамгай эмчлэгчид шалгаруулан байр эзлүүлж, урамшуулна. Үүнд: Худалдаа, нийтийн хоол, талхны Үүнийг хийхэд 80 хувь хэвэг, 10 хувь хужир, 0,5 хувь чихэр, 0,5 хувь ясны үнс найруулан хийжээ.

Мөн 10 хурга, ишгэнд 1 элгэнч, нэмээ, 2,5 төлд хурганы 1 уут ноогдоосор бодог нэмнээ, элгэнч 71, дут 28, хаг хаях дэгээ төмөр 10 ширхэг, төлчин бүр гарын бээлий, хөөр ээлжийн халаз зэргийг тус тус бэлтгэсний дээр мал эмнэлгийн тургэн тусламжийн эмийн сан I, гэрийн дэнлүү 2, эх төлийн бүртгэл, номыг төлдөх малын тоогоор бэлтгэж, ээлжийн жижүүртэй болгон ажиллуулахаар хүмүүсээ хувиарлан бэлтгэжээ.

Энэ суурийнхан хотныхоо гадна дотнын хог новшийг тогтмол цэвэрлэж, бие засах байр, хог, муу усны хүх, морины уяа зэргийг хүртэл алс, тохиромжтой газар бэлтгэсэн байна.

Энэ бүх ажлыг гүйцэтгэхэд тус суурийн төлчин Норжин, Даш, Дулам, Жавзэнсэлэм, Цагаанхүү, малчин Даржаа, Намсрай, Чойжин, Сандуйжав, Дашзэвэг нар тун идээх чармайлттай ажилласан байна.

Тус суурийн хамт олон 705 хонь, ямаанаасаа 705 хурга, ишиг бойжуулахаар үүрэг аваад амлалгаа ажил болгож, «төл болгоныг мал болгохын төлөө» гэсэн нам засгийг удаа цогтой уриа д зоригжин, МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын заалтыг биелүүлэхийн төлөө шуурхай ажиллаж байна.

Баянзүрх сумын намын үүрийн дарга.

Р.Дондонжав

газар, бэлтгэлийн ажилд хэрэглэх шинэ машин, техник, аппарат, багаж хэрэглэл санаачлан гаргаж, ажилд нэвтрүүлэн, хэргэлсэн бол худалдаа бэлтгэлийг удирдах газрын үнэмлэх, 1600 төгрөгөөр; худалдаа, нийтийн хоол, талхны газар, бэлтгэлийн хүнд хүчир ажлыг хөнгөвчилсөн техник хэрэгслэлийг санаачлан, цахилгаанаар ажиллаж, өндөр бүтээл гаргаж чадсан оновчтой санал бол худалдаа бэлтгэлийг удирдах газрын үнэмлэх, 1000 хүртэл төгрөгөөр; худалдаа, нийтийн хоол, талхны газар, бэлтгэлийн ажиллагааг хөнгөн шуурхай болгох техник санаачлан, цахилгаанаар ажиллахгүй боловч механик, гар ажиллагаанаас нилдээ давуутай бүтээл гаргах нөхцөлтэй бол худалдаа бэлтгэлийг удирдах газрын үнэмлэх, 800 төгрөгөөр тус тус шагнах юм.

Шинэ бүтээл, оновчтой санал, төргүүн туршлага, ажлын дэвшилттэй аргыг өөрийн байгууллагын хэмжээн дээр өрнүүлэх ажлыг үлгэр жишээгээр зохион байгуулж, үйлдвэрлэлд түргэн нэвтрүүлж, хэрэгдсэн буюу өөрийн өдөр дутчин ажилд чадамгай хэргэлсэн худалдаа бэлтгэлийн ангийн дарга, нягтлан бодогч, бусад ажилчин, ажилтаа, тэдний гүйцэтгэсэн ажлын байдал, гаргасан үр дүнг харгалзан мөнгөн шагнал олгоно.

Оновчтой саналын уралдаанд аль системийн хэвч оролцож болно.

Харин гаргасан санал нь аймгийн худалдаа бэлтгэлийн аль нэгэн байгууллагын ажилда хэрэглэгдэн нэвтрэсэн байвал зохино.

Гарч байгаа оновчтой саналыг загвар, зураг, эдийн засгийн тооцоо, техникийн зохион байгуулалтын тодорхойлолт, ашиглалтын заавар, зохиогчийн тодорхойлолт зэргийг сумын худалдаа бэлтгэлийн ангийн дамжуулагч, худалдаа бэлтгэлийг удирдах газарт ирүүлнэ.

Худалдаа бэлтгэлийг удирдах газрын шинэ санаачлага, оновчтой саналын комисс нь уралдаанд шалгаруулах, техник, хэрэгслэлийг аймгийн төвд авчруулах буюу эсвэл газар дээр нь очиж биечлэн шалгана. Болзлын дүнг 1962 оны 11 дүгээр сарын 1-нээс 30-ны дотор худалдаа бэлтгэлийг удирдах газрын шинэ санаачлагын комиссоос шалгаруулан гаргаж, аймгийн шинэ санаачлагын комиссоор батлуулсны дараа шагналыг аймгийн худалдаа бэлтгэлийг удирдах газраас олгоно гэжээ.

Төлийн бэлтгэлийг хангасан суурь

Баянзүрх сумын Сүхбаатарын эм нэгдлийн 5 дугаар бригадын Дашдэлгэр ахлагчтай хонины суурь, энэ жил төлдөх 705 хонь, ямааны төл хүлээн авах бэлтгэлээ бүрэн хангажээ.

Тус суурийнхан 1961 оны 12 дунд сард Хэрлэнбайн улааны «Баян Хамба» гэдэг газар нүүдэллэн очсон юм.

Хонь, ямааг хашаа хороогоор хангахад материалын бэрхшээлтэй тулгарсан боловч хүн бүр гар хумхилгүй ажилласны үрээр дотор нь таван тасалгаа бүхий 100 малын багтаамжтай төлийн, пүнзийг орон

ниулсны үрээр 1961 онд аймгийн хэмжээгээр нэгдүүдийн 118 бригад төвлөрөх газраа тогтоож, тохиожж байна.

Жаргалантын сангийн аж ахуйн агрономч нөхөр Гомбо, Жанчив нар, 1960 онд ногоо хадгалах галлахгүй зорь санаачлан хийснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэг дахин нэмэгдүүлж, өөхөө 1 жилд ногоог хадгалах ба зоройн барилга, ажилчдын шууд зардлаас 140 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан туршлагыг 3 сангийн аж ахуй, 12 нэгдэлд нэвтрүүдэв.

Тус аймгийн сангийн аж ахуйнуудад үнээг хайдагшуудын саах туршлагыг нэвтрүүлж, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Авирмэдийн туршлагыг бүх сум нэгдлийн саальчдад нэвтрүүлсний дунд 12 сум нэгдэл үнээг төвлөрүүлэн суурьшуулж савнаас сүүийн гарцыг 5 хувиар нэмэгдүүлжээ.

Мял нэг бүрээс ашиглах ноосны гарцыг нэмэгдүүлэхийн тулд ямаа бүрээс 280 гр, ноолуур, 230 гр ноос ашигласан Угтаацайдан сумын малчин Эрээрүүлхүүбэ, нутгийн хонь бүрээс 1350 гр ноос, ашигласан Бүрэн сумын малчин Дондог, үхэр бүрээс 560 гр хөөвөр ашигласан, Өндөрширээт сумын малчин

нутгийн материал хөрөн, модоор тохилог сайхан барьж хурга, ишгээ ахээр, хөрөвжилтийн үе шатнаар бойжуулах бэлтгэлтэй болжээ.

Төлийн бэлтгэлийг хийхэд төлнэг бүрд өдөр дутамд хэрэглэх зүйлийг тооцоолон гаргаад хурга, ишгэнд өдөр дутамд 20 гр хужир, цагаан өвс 200 гр, бууц 600 граар бодож хужир 1500 кг, өвс 10 тонн, бууц 4500 кг-ыг бэлтгэн авч, төлд өгөх хүчит тэжээл хэвэг, хужир, чихэр, ясны үнс найруулан, дундаа нүхтэй дугуй хэлбэрийн эрдэс тэжээл бэлдсэн байна.

Зуу-наст, адуу бүрээс 450 грамм хөөвөр, 400 грамм хялгас ашигласан Алтанбулаг сумын Гомбосүрэн нарын туршлагыг нийтэд эзэмшүүлэх ажил зохиож байна.

Гүү бүрээс 360 литр сүү ашигласан Өндөрширээт сумын малчин Жанчив, ямаа бүрээс 20 литр сүү ашигласан Тариат сумын малчин Дугар, хонь бүрээс 15 литр сүү ашигласан Эрдэнэсант сумын малчин Дэнсма нарын туршлагыг тус аймгийн хөдөө аж ахуйн 21 нэгдэлд нэвтрүүлэв.

Аймгийн үйлдвэрийн газруудад 1961 онд шинэ санаачлага, төргүүн туршлага 52 гарч, 31 нь ажилд нэвтэрч, 261,6 мянган төгрөгийн цэвэр ашиг олжээ.

Хувсний комбинатын ажилчин Долгор, 15 жил тасралтгүй, нормоо давуулан биелүүлж ирсэн туршлагыг 12 хүнд эзэмшүүлж, комбинатын хэмжээгээр 1961 оны эхний 3 улиралд хөдөлмөрийн бүтээмжийг 14,2 хувиар нэмэгдүүлж, өөрийн өртгийг 4,1 хувиар хямдруулан, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 104 хувиар биелүүлсэн юм.

Үйлдвэрлэлийн хорьоллолын холбоо, 1961 онд Улаанбаатар хотын модны артелийн туршлагыг эзэмшин

модоор мебель өдлөл хийж чаддаг боллоо.

Худалдааны байгууллагын хэмжээгээр 1961 онд шинэ санаачлага, төргүүн туршлага 29 гарсан 20 нь ажилд нэвтэрч, Баянчандмань сумын худалдаа бэлтгэлийн ангийн гуанзны тоогоо Өвчин-пуу, Цэрэнхүү нар маслын шахуурга зэрэг 10 гаруй зүйлийн шинэ санаачлага туршлагыг сумын худалдаа бэлтгэлийн ангийн гуанзнуудад дэлгэрүүлэн, хэрэглэснээр нийтийн хоолны нэр төрлийг 34,5 хувиар нэмэгдүүлж, аймгийн төв, Баянчандмань, Жаргалавт, Зорголын уурзайн гуанзнууд 10-15 нэр төрлийн хоолоор хөдөлмөрийг үйчиддэг боллоо.

Заавар сумын худалдаа бэлтгэлийн ангийн туршлагаар нийт сумын худалдаа бэлтгэлийн ангийн дэлгүүр агуулахуудыг бүрэн буюу хагас төрөлжүүлж өдөр оруулж, бүртгэл хөтлөлтийг тогтмолжуулж, төллого тооцооны ажил сайжирлаа.

Тус аймгийн 13 дугаар авто баазан бүх тээврийн машины 43 хувь нь чаргуудтай болсон зэрэг аймгийн ардын аж ахуй, соёлын салбарт шинэ санаачлага, төргүүн туршлагыг дэмжин дэлгэрүүлж байгаагийн үр ашиг ингэж гарч байна.

Шивийг санаж, ихийг бүтээж байна


Баянчандмань сумын артелийн Цэлэнсэмдүү ахлагчтай СХТ Бригадын гишүүн, гуталчин Чөлөө улсын хэмжээгээр баримталж байгаа хуучин нормыг эвлэж шинэ норм тогтоожээ.

Чөлөө, ингэж шивийг санаачилснаар нэг гутал хийлэг цагийг 20 минутаар хэмнэж, 8 цагт том хүний гутал 8-9, хүүхдийн гутал 10-12-ыг хийж, хөдөлмөрийн бүтээлийг 24 хувиар нэмэгдүүлж, олон арван төгрөгийг хэмнэж, сайхан амжилт гаргасан байна.

Гуталчин Чөлөө, 2 дугаар сарын эхний 15 хоногийн төлөвлөгөөг хугацаанаас нь 2 хоногийн өмнө 35 хувиар давуулан биелүүлжээ.

Д. Дондогдорж

Эцэг эхчүүдэд зөвлөлгөө



Архустын САА-н шуудан тасгийн эрхлэгч Шагдарсүрэн, холбоочоор 10 жил ажиллахдаа хөдөлмөрдийг холбоогоор шуурхай сайн үйлчилж, харилцаа шингэлтийн төлөвлөгөөг биелүүлдэг туршлагатай болжээ. ЗУРАГ ДЭЭР: Холбоочин Шагдарсүрэн эжил дээрээ байгаа нь: Зургийг Д. Дон догдорж

Багш нарын III их хурлын шийдвэр, амьдралд хэрэгжиж байна

Эрдэнэсант сумын Чойн эрхлэгчтэй сургуулийн багш, үйлчлэгч нар улсын багш нарын III их хурлын шийдвэрийг судалж ажилдаа тусган, суралцаад сурлага, хөдөлмөрийн бат мэдлэг олгож байна. Тус сургуулийнхан 1961-1962 оны хичээлийн жилд орон нутгийн материал амнглаж, 50 хүүхдийн лотуур байр өөрсдийн хүчээр барьжээ.

Сурагчдад оройн цагаар явуулах хүмүүжил, олон төрлийн дугуйлин, хөдөлмөрийн дадлага хийх булангуудыг үзүүлэн таниулах зүйлээр төхөөрөмжлөн засч, хичээлийн биш цагаар сурагчдын дотор зохиох ажлыг нарийн хуваартай явуулдаг болжээ.

Өөрөө өөртөө үйлчлэх буланд Оёдлын ба усний машин, арнуу цэвэрлэн хэрэглэл, зуу утас, гутлын тос, сойз, гэр ахуйн цахилгаан хэрэгслэлийг тавьж, сурагчдаар үйлчлүүлдэг болсон нь сурагчид үсээ авч, хувцсаа өгж, цахилгаан индүү хэрэглэж сурч байна.

Сургуулийн захиргаа, эцэг, эхийн хороотой хамтарч, сурагчдын дотор арнуу цэвэрлэх, ахмад настныг хүндлэх, хичээлээ давах, гэр орны ажилд туслахтай холбогдсон товч яриа байнга хийдэг байна.

Үүний үрээр сурагчид хувцсаа цэвэр өмсөх, гутлаа арчих, үс толгойгоо угаах, хумсаа авах, ахмад настныг хүндлэх зэрэг соёлч байдлыг нийтээрээ эзэмшиж байна.

Сургуулийн захиргаа, хүүхдийг сургаж хүмүүжүүлэхдээ, эцэг эхтэй нь өдөр дутам харилцаж, гэр орноор нь явах, эцэг эхийн шуурхай зөвлөлгөөнийг хийх, хичээл дээрээ эцэг эхийг урьж суулгадаг болсон нь хичээл заалтын чанарыг сайжруулах нэг чухал нөхцөл болжээ.

Тус сургуулийн багш нар хичээлээ үзүүлэн таниулах зүйлээр баяжуулан, нам зөвгийн ээлжит зорилт, олон улсын дундын байдла, аймаг сумын төлөвлөгөөг ажил зэрэг орчин үеийн чухал сэдэвтэй нягт холбоон заадаг болсон нь сурагчдад улам ч илүү ойлгоц өгч байна.

Сургуулийн захиргаа, зөвлөлтийн ба ардын ардчилсан орнууд, өө-

рийн орны пионер сурагчдын сурч, амьдарч байгаа үйл амьдралыг харуулсан фото самбар 3, өөрийн сургуулийн 5 онцыг эзэмшигчдийн туршлагыг бичсэн самбар 2, үзүүлэн таниулах зүйл 76-г хийж, пионериин булан, анги танхимдаа тавьсан байна.

Сургуулийн багш нар сурагчдын дотор 5 онцыг эзэмших хөдөлгөөн өрнүүлж, сурагчдыг хөдөө аж ахуй, техникийн мэдлэгтэй болгох зорилгоор нэгдэл, станцын тариа, ногоо хураах, хадлан авах, мал саах, носс үс авах, мал төлүүлэх ажилд туршлагын журмаар ажиллуулдаг байна.

Одоо сургуулийн дэргэд шатар, даам, дуу бүжиг, биеийн тамир спортын зэрэг 10 дугуйлаанд 130 гаруй пионер сурагчид суралцаж, 5 онцыг эзэмших соёлч нөхөрлөл 3 ажиллаж, 2 дугаар улирлаар муу дүнтэй гарсан 19 хүүхдийг шөфлэн авч тэдний хичээлд туслах, хамтран ажиллаж байна.

Тус сургуулийн багш нар 5 онцыг эзэмшин, 4 жил дараалан онц сурсан пионер Сономдулам, онц сурлагатаан Дашдэндэв, Гунгаадорж, Гунгаажанцан, Норовсүрэн нарын 30 хүүхдийн туршлагыг нийт сурагчдад эзэмшүүлэх, гурван хүүхэд нь 2-3 жил дараалан онц сурч байгаа эх Банзрагчийн туршлагыг эцэг эхчүүдэд эзэмшүүлэх ажлыг зохиож байна.

1961-1962 оны хичээлийн жилийн 1 дүгээр улиралд сургуулийн хэмжээгээр 86 хувийн сурлагын дүн үзүүлж, 8 хүүхэд муу дүнтэй сурч, ангиа 100 хувь сургаасан багш байгаагүй бол 2 дугаар улиралд сургуулиараа 90,8 хувийн дүн үзүүлж, багш Минингбазар, Эрдэнэдалай нарын харнуцсан анги 100 хувийн сурлагын дүн үзүүлжээ.

Одоо тус сургуулийн багш, ажилчинд МХЗЭ-ийн 14 дүгээр их хурлыг угтаж 1961-1962 оны хичээлийн жилийн 3 дугаар улирлаар сургуулиараа 100 хувийн сурлагын амжилт үзүүлж, багш нарын III их хурлын уриалгыг биелүүлэхийн төлөө ажиллаж байна.

Данларын

АВЬСЛАГ ПИОНЕР

Дэлгэрхаан сумын бага сургуулийн 4 дүгээр анги д пионер Дашдулам суралцадаг. Энэ пионер хичээлдээ сайн суралцаад зөсгөдөггүй хичээлээс гадуур явагддаг төрөл бүрийн дугуйлангуудад идэвхтэй

суралцаж, «Зуу модны гол» «Зун» «Манай нэгдэл» «Ардын багшийн алдар» зэрэг 50 гаруй дууг сайхан дуульдаг гадна 10 гаруй бүжгийг чадамгай хийдэг болжээ.

Ц. Дамба.

Бидний үр хүүхэд бол манай байс галайт ирээдүй, амьдралын эцэг мөн. «Үр олонг үндэсний тулгуур» «Хүн болох багсаасаа, хүлэг болох унагаанаасаа» гэх мэт сургаалууд ард түмний дотор олон бий.

Та бидний хэн маань ч гэсэн олон үр хүүхэд төрүүлж, зөв боловсон хүмүүжилтэй сайн сайхан хүмүүс болгохыг зорьдог. Хүүхэд нь орчин ахуйн байдлыг сэтгэлдээ тусгаж байдаг учраас хүүхэдтэй харьцах харьцаа зөв байх ёстой.

Хүүхдийн хүмүүжил, бүр бага наснаас эхлэх ёстой.

Хүүхдийн ихэнх цаг нь гэр орны газар байх учир эцэг, эх, төрөл төрөгсөд бол хоёрдахь сургууль нь мөн. 2-3 насны хүүхэд өмгийн тохиолдуудаараа өлдөв юманд тавар цаглаж ойчих, дээл хумсаа урах, аяга тавгаа хагалах зэрэг үзэгдлүүд олонтой гардаг. Гэтэл зарим нэг эцэг, эх, хүүхдээ чулуунд тавар цаглаж ойчоод уйлахад, ээж нь чулууг зодно гэх буюу хадаасанд дээлээ урахад эцэг нь өнө муу хадааснаас болов, хэрэв аяга хагалах бол шалнаас ч болдоо гэх зэргээр үгүүлж, уг зүйлийн бурууг хүүхдэдээ өгдөггүй байна.

Энэ арга нь тэр үедээ сайн мэт санагдаж, хүүхэд уйлахаа болих явдал байх боловч зөв сургаж бишээ. Хүүхэд 3 нас хүрмэгц өөрөө ойчсон юмаа зодох, 5 наснаасаа өөрийн бурууг найз нөхөддөө өгөх, сургуульд ороод, бяцгээ муухай болвол үзэг, бэх, дэвтрээс болов гэх зэргээр дутагдлаа хүлээхээ болж, багшийн үг сургаж, нөхдийнхөө шүүмжлэлийг хүлээж авахдаа муу болдог байна. Ийм учраас бүр багаас нь эхлэн өөрт нь дутагдлыг нь хэлж ойлгуулах хэрэгтэй. 2-3 насанд нь хөлөө чанга гингнэж яв! Юмыг боломжоотой хий! гэж сургах, эсвэл аяга хагасны учир цай уух аяга дутагдав гэж учрыг нь

ойлгуулах ёстой. Хүүхдийг бага наснаас нь хөдөлмөр хийлгэх ёстой. Энэ ч зүй ёсны хэрэг. Тоглоомоо өрөх, хураах, хувцсаа арчих, өмсөх, өлгөх, сан суулгаа угаах, арчих зэргээс эхлэх ёстой.

Харин хөдөлмөр нь хүүхдийн насны байдла, хүч, сонирхол зэрэгт тохироогүй, багаж нь биенд нь тохиромжгүй хугацаа нь урт зэргээс шалтгаалж биений өсөлт нь өөрчлөгдөх, гэр, хөл, зэрэг нь эвдрэх явдлыг анхаарч, хүүхдэд тохирсон ажил өгөх хэрэгтэй.

Эцэг, эх нь ажлын арга барилыг өөрөө зааж өгөхийн хамт багажийг нь өөрт нь тохируулж, бэлтгэхээс гадна 3-7 насны хүүхдийн нэг төрлийн ажлыг үргэлжлэх хугацаа нь 2-10 минут байх ёстой.

Харин осол гаргах, хутга, хайч, сүх, хөрөө, буу зэргийг эзэмшүүлэх нь буруу юм.

Зүг, чиг, хол, ойр, их, бага, өнгө, зүс зэргийг зөрөөтэй хэлснээс болж, хүүхэд хууртагдах явдал гардаг.

Жишээ нь: Хойт авдар дээрээс аяга авчир гэтэл, урьд авдар дээр байх, үүнээс болж, хүүхэд нь үгэнд нь итгэхгүй болж сүүлдээ, үнэн бнээ? гэж асуух, ажилд явахдаа дургүй болдог төлийгүй үгэнд итгэхгүй болдог. Ер нь хүүхдэд хэлсэн үг заавал үнэн байх хэрэгтэй.

Хэрэв та хүүхдээ хуурвал, хүүхэд чинь таныг, хуурна. Мэлэхгүй үгийг нь мэдэх үгэнд туагуурлаж тайлбарлаж өгөх ёстой.

Энэ мэт наад захын үзэгдлүүд дээр ч зөв хүмүүжил олгохыг анхаарч байвал зохино.

«Залуурын дэргэдэх мод шулуун» гэгчээр хүүхдийн дэргэдэх орчин зөв сургажмаар цалгиж байвал та бидний үр, ач нар эх орноч эв хамтын хүмүүжилтэй, эрдэм мэдлэгтэй иргэд болж чадна.

П. Очир-бат.

Хаагуур төрөө бол

1961 онд Тариат суманд захиалсан хэвлэлийг тоо бүртгэлийн байцаагч Гэлэнхүү тарааж байхдаа ирсэн хэвлэлийг цаг тухайд нь хувааж тараахгүй өр зээлийн чанартай нэхүүлээд ч өгөхгүй байснаас ширээ шүүгч дүүрэн, сонин, сэтгүүдтэй шинэ ондоо золгож, сэтгэл нь жаахан түгшин, хэд хэдэн хэсэг болгоод брнгадуулаад хүргүүлж байсан юм.

«Эх нь хээр алаг бол, унага нь шийр алаг» гэгчээр сумын нарийн бичгийн дарга Дамба, 1962 онд хэвлэл тараах ажилд урьд гарч байсан урагшгүй дутагдлыг давтаж эхэллээ Мал эмнэлэгт 2 дугаар сарын 10-ны байдлаар намын үнэн 12 ширхэг, СХАА сонин 4 ширхэг, аймгийн «Анхдугаар таван жил» сонин гуравхан дугаар иржээ.

Арав шахам нэхүүлж байж 2 дугаар сарын 14-ний өдөр бөөн сонин өхөөр нь баяр бэхдэл болж, дугаарлахаар шүүрдэж эхэлсэн маань намын үнэн сонин 13, 14, 15, 17, 31, 36 дугаар, СХАА сонин 1, 3, 4, 5 дугаарууд нь тус тус дутуу байлаа. Цааш нь үлдсэн баахан сонинныг хутгаж үзэхэд хоосон байхвар, гар сарвайлгана гэсэн юм шиг намын үнэн сонин 33, 34, 35, 3, 37, 38 дугаарууд болон хөдөлмөр сонин 17, 18, 20, 21, 22, 23 дугаар давхардаж иржээ.

Аа хөөрхий зайлуул, миний дутуу

сонин хаагуур төөрчихөөд, хэний сонин үүгээр тэнэж яваа юм болдсо. Хөдөлмөрдлийн захиалсан хэвлэлийг хугацаанд нь шуурхай, зөв тарааж байхыг захиалагч олон түмэн нөхөр Дамбаас зүй ёсоор шаардаж байна.

Г. Базарсад

ХЭВЛЭЛ ХУВААРЛАЛТАНД АНХААРМААР БАЙНА

Баяндэлгэр сумын Хэрлэнбаян нэгдлийн 2, 3, 4 дүгээр бригад, уржил хонин фермийн хөдөлмөрчид, Хэрлэнбаян улсад отроор явж, 1962 онд хэвлэлийг харилцаа холбооноос шууд хүлээн авдаг боловч хэвлэл нь дутагдаж, дугаар алагач очих явдал ердвийн болжээ.

Энэ нь 1 дүгээр сарын 17-нд очсон сонин дагаварт намын үнэн сонин дөрвөн дугаар явуулсан гэж бичсэн боловч тэр нь байхгүй байлаа.

Социалист хөдөө аж ахуй сонин 10 дугаар нь ирээгүй 6, 9 дүгээрээс тус бүр 2, хөдөлмөр сонин 6, залуучуудын үнэн сонин 15, 16 дугаараас тус бүр 16, аймгийн сонинноос 45 дутуу очжээ.

Солмон

Хариуцлагатай эрхлэгч С. ДИНСМАА.